



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 17/13

Улаанбаатар хот

Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхлыг
дээдлэн бэхжүүлэх тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл "Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхлыг дээдлэн бэхжүүлэх тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшингийн илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

1.1. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах, үндэсний хэв шинжийг бүрдүүлэх, үндэсний нэгдмэл ухамсар, үзэл санааг төлөвшүүлэх талаар нийгмийн зөвшилцөл, нэгдсэн ойлголтод хүрч, тууштай баримтлахыг Монгол Улсын төр, улс төрийн нам, иргэний нийгэм болон нийт иргэдэд уриалах.

Хоёр. Монгол Улсын Их Хуралд:

2.1. Үндэсний эв нэгдлийг алдагдуулж буй хүчин зүйлсийг арилгах улс төр-эрх зүйн арга хэмжээг төлөвлөж авах;

2.2. Үндэсний эв нэгдэл, язгуур эрх ашгийг дээдлэх үзлийг төрийн үйл ажиллагааны суурь зарчим болгож хэвшүүлэх, энэ чиглэлд үндэсний зөвшилцөл бий болгох;

2.3. Үндэсний хөгжил цэцэглэлт, мандан бадралд ард иргэдийг нэгтгэн дайчлах үндэсний нэгдмэл мөрөөдлийг бүрдүүлж хэрэгжүүлэх.

Гурав. Монгол Улсын Засгийн газарт:

3.1. Үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдалд сөрөг нөлөөлөх эрсдлийн үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах;

3.2. Үндэсний хэв шинжийг бүрдүүлэх талаар төр, нийгэм, улс төр, соёл, боловсрол, эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаа болон иргэдийн оролцоог нэгтгэн чиглүүлсэн үндэсний хөтөлбөр боловсруулж батлан хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

М.ЭНХБОЛД

Ж.ЭРДЭНЭБАТ

ХУУЛБАР ҮНЭН: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.ЭНХТҮВШИН

